


ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВИЙН (ХЭХТ) 2023 ОНД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

- Монгол Улс Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэлээ НҮБ-ын Дээд түвшний улс төрийн чуулганд 2023 онд танилцуулсан. Үүнийг тохиолдуулан “Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) ба Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)” Сүлжээний гишүүд ТХЗ-ын хэрэгжилтийг үнэлэх, улмаар Иргэний нийгмийн хоёрдугаар нэгдсэн илтгэлээ боловсруулан ажилласан. Энэ ажлын хүрээнд ТХЗ-ын хэрэгжилтийг оноогоор үнэлэн дүнг бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч төрийн албан хаагчид, иргэний нийгэм, орон нутгийн болон олон улсын байгууллагууд, иргэдийн төлөөллөөр хоёр удаа хэлэлцүүлсэн юм. Эдийн засаг, хөгжлийн яам, НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр “ТХЗ ба ИНБ” сүлжээ, Хүний Эрх хөгжил төв хамтран **“ТХЗ-ыг оноогоор үнэлэх олон талын оролцоотой уулзалтыг** 2023 оны 1-р сарын 4-нд Пума зочид буудалд амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтыг Эдийн засаг, хөгжлийн яамны ажлын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх мөн НҮБ-ын Суурин зохицуулагчийн газрын Стратегийн ахлагч Э. Должинсүрэн нар нээж үг хэлэв. Тус арга хэмжээнд төрийн яам, агентлаг, орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурал, хувийн хэвшил, иргэний нийгэм, олон улсын байгууллага, иргэд, судлаачдыг төлөөлсөн 80 гаруй хүмүүс оролцож, ТХЗ-ын хэрэгжилтийг оноогоор үнэллээ.



- Азийн хөгжлийн сүлжээ олон улсын байгууллагын (ADN) санхүүжилтээр **“Ардчиллын үнэлгээ, сорилт ба иргэний нийгмийн оролцоо”** сэдвээр ХЭХТ нь иргэний нийгмийн мэдлэг, туршлага дээр суурилж 200 хүнээс судалгаа авав. Тус судалгааны зорилго нь ардчиллын сорилт, ухралтыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, ардчиллын дэмжигчдийн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний эв нэгдлийг бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх зорилтготой юм. Судагааны үр дүнгээс танилцуулбал





➤ Газрын багц хуулийн төсөлд

“Эмэгтэйчүүд нэгдээрэй! Shift the power! системийг өөрчил”

➤ УУЛ УУРХАЙ МАЛЧДЫН АМЬДРАЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙНА ВЭ?

Хүний эрх хөгжлийн төв нь Форум Ази олон улсын хүний эрхийн байгууллагатай хамтран 2022 оны 10-р сард уул уурхайн үйл ажиллагаанаас болж байгаль орчин, мал, нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сумуудад баримт нотолгоо нь дээр суурилсан судалгааны ажил хийж, тайлан гаргасан. 2023 оны 4-р сарын 10-нд УБ хот, 4-р сарын 12-нд Сайншанд хотод хэвлэлийн бага хурал зохион байгуулж судалгааны ажлын тайлангийн үр дүнг танилцуулсан юм. Уг илтгэлд тус 3 сумдуудад малчид, тэдний гэр бүлийнхэнд тулгарч буй бэрхшээлийн талаар өөрийн биеэр танилцуулж, уул уурхайн үйл ажиллагаа нь тэдний эрүүл мэнд, амьжиргаанд төдийгүй мал, амьтныг хамгаалах язгуур эрхэнд нь хэрхэн аюул учруулж, усны эх үүсвэр бохирдож, хүн, малыг хохироож байгаа нь малчдын орлогыг бууруулж, гэр бүлээ тэжээхэд хүндрэл учруулж байгааг онцолсон. Мөн уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдол нь эрүүл мэндийн ноцтой асуудал, тэр дундаа эмэгтэйчүүд, нярай хүүхдийн зулбах болон бусад эрүүл мэндийн асуудлуудад гарч байгааг дүгнэж гаргасан юм.

➤ "Эрдэс баялгийн салбарын эрх зүйн шинэчлэл: Орон нутгийн харилцаа" сэдэвт цахим хэлэлцүүлэг. 2023 оны 6-7 р сард 21 аймагт "Эрдэс баялгийн салбарын эрх зүйн шинэчлэл:

Орон нутгийн харилцаа" сэдэвт цахим хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм Форум, Хүний Эрх Хөгжил Төв, Хил хязгааргүй алхам ТББ-уудтай хамтран зохион байгууллаа. Тус цахим хэлэлцүүлэгт 1000 гаруй 21 аймгийн төрийн албан хаагч ЗД, ИТХ, багийн засаг дарга, байгаль орчны ажилтнууд болон малчид иргэд идэвхтэй оролцлоо.



- МХБХ-ны 17 дахь Туршлага солилцох уулзалт, Ханбогд сум, Өмнөговь аймаг, 2023 оны 7-р сарын 20-26
- Ардчиллыг бэхжүүлэх нь: “Иргэний нийгмийн оролцоо” Үндэсний хэлэлцүүлэг 2023 оны 8-р сарын 1, УБ хот
- ТХЗ-ын хэрэгжилтийн үнэлгээ ба хэрэгжилтийг хурдасгах бодлогын зөвлөмж” ТХ-ийн төлөөх ИНБ-ын Сүлжээний хэлэлцүүлэг, 2023 оны 8-р сарын 16, УБ хот

2023 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТУУД БА СУДАЛГААНУУД:

1. “Тогтвортой хөгжлийн зорилгуудын тухай ба үндсэн ойлголт” сургалт, 2023 оны 9-р сарын 7-14, Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах, Хатанбулаг сум
2. “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хор хохирлын тухай” ИРГЭД МАНЛАЙЛСАН сургалт ба судалгаа Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Дорнод аймгийн Баяндун сум, Хэнтий аймгийн Мөрөн сум, 2023-2024
3. “Хүний Эрхийг хамгаалах үндэсний болон олон улсын механизм, байгаль орчин, газар, ус ашигт малтмалын тухай мөн ХЭХ-ийн эрх зүйн байдлын тухай” сургалт, 2023 оны 10-р сарын 13-15, Дорноговь аймгийн Сайншанд хот
4. “Бизнес ба Хүний эрх” ИРГЭД-МАНЛАЙЛСАН сургалт ба судалгаа 2023 оны 11-12 сар Өвөрхангай аймгийн Арвайхээр сум
5. “Хүний эрхийн хамгаалагчдын эрсдэл ба аюулгүй байдал” сургалт, 2023 оны 12-р сарын 8-9, УБ хот

**ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ҮНДЭСНИЙ 5-Р ЗӨВЛӨГӨӨН: “ХҮНИЙ ЭРХ,
ХӨГЖЛИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ НЬ,” УБ хот, 2023 оны 12-р сарын 11-12**



Форум азийн санхүүжилтаар ХЭХТ нь Глоб Интернэшнл байгууллагатай хамтран 5 дахь удаа ХЭХ-ын Үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулсаар ирсэн. Энэ удаагийн ХЭХ-ын Үндэсний 5-р зөвлөгөөн нь 2023 оны 12-р сарын 11-12-ны хооронд УБ хотод амжилттай зохион байгуулж хөдөө орон нутгийн ИНБ, ХЭХ-чийн эрх зүйн орчин, үзэл бодлоо илэрхийлэх эрх, мэдэх эрх, хөгжил дэх хүний эрхийн асуудлаар мэргэшсэн шинжээчид мөн УБ хот болон орон нутагт хүний эрх, байгаль орчны хамгаалал, нийгмийн хөгжлийн асуудлаар ажиллаж буй залуус, ахмад настан, иргэний нийгмийн төлөөлөл нийт 90 хүн оролцлоо. Бид ХЭХ-ын үйл ажиллагааг дэмжсэн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмэр оруулах зорилгоор дараах зорилтуудыг тавин ажилласан. Үүнд:

1. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдлийн тухай мэдээлэл, санал солилцох
2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, иргэдийн мэдэх эрхийн хэрэгжилт, орон нутгийн ХЭХ-дад тулгамдаж буй асуудлууд, шийдлийг тодорхойлох
3. Хөгжлийн асуудлаар ХЭХ-дад тулгамддаг асуудал, шийдлийн тухай мэдээлэл, санал солилцох

➤ ХЭВЛЭН НИЙТЛЭЛ /2023 он/

